



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/240

Эрдэнэт

Шагнах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 тогтоол, аймгийн Засаг даргын 2013 оны А/619 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд мөрдөх Орон нутгийн Захиргааны байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 54 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн V хуралдааны 2 дугаар тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2016 оны Үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр өндөр үнэлгээ авсан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газрыг тус бүр өргөмжлөл, 3.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Дээрх шагналд шаардагдах 15 275 000 /Арван таван сая хоёр зуун далан таван мянган /төгрөгийг Засаг даргын бусад зардал- / Хяналт-шинжилгээ, үнэлгээ зохион байгуулах/-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Шагнагдах байгууллагын нэрс	Шагналын хэмжээ
<b>Байгууллагын шагнал</b>		
1.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	3 000 000
2.	Онцгой байдлын газар	3 000 000
3.	Стандарт хэмжил зүйн хэлтэс	3 000 000
4.	Татварын хэлтэс	3 000 000
5.	Орон нутгийн өмчийн газар	3 000 000
<b>Дүн</b>		<b>15 000 000</b>
<b>Өргөмжлөл хэвлүүлэх зардал</b>		
1.	Өргөмжлөлийн үнэ 55 000 х 5	275 000
<b>Нийт дүн</b>		<b>15 275 000</b>